



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/68

Хэрлэн сум

Цэргийн бэлтгэл албаны сургалт зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалт, Цэргийн албаны тухай хуулийн 33.2, Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2017 оны н/03 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу бэлтгэл офицерын мэргэжил эзэмшүүлэх сургалтыг 2017 оны 03 дугаар сард, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний давтан сургалтыг 05 дугаар сард, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтыг 09 дүгээр сард Зэвсэгт хүчний 232, 327 дугаар ангитай хамтран зохион байгуулсугай.

Хоёр. Сургалтад зарцуулагдах төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

Гурав. Хавсралтад нэр заасан цэргийн бэлтгэл үүрэгтэн нэг бүрт мэдэгдэх хуудас хүргүүлж тогтоосон хугацаанд, заасан газарт бэлэн байлгахыг сумдын Засаг дарга нарт, цэргийн сургалтад оролцох хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаалыг хэвээр хадгалахыг холбогдох байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Дээрх сургалтуудыг зохион байгуулахад шаардагдах 3000000 /Гурван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн цугларалт, бэлтгэл сургууль, дайчилгаа, түр цэргийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 407

Аймгийн Засаг даргын 2017 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт

Дайчилгааны бэлтгэл албаны сургалтын төсвийн тооцоо

№	Сургалтын төрөл	Хамрагдах хүний тоо	Хугацаа /хоног/	Төсөв		Хянасан
				Орон нутгийн төсөв	БХЯ-ны санхүүжилт	
1	Бэлтгэл офицеруудын сургалт	13	14	1000000	1506000	
2	1-р зэргийн бэлтгэл үүрэгтний сургалт	45	14	0	3100000	
3	2-р зэргийн бэлтгэл үүрэгтний сургалт	45	14	2000000	3100000	
	Бүгд			3000000	7706000	